

КОМПЛАЕНСИЙН АЖИЛТНУУДАД ЗОРИУЛАВ

2024.06.13

# СЭЖИГТЭЙ ҮЙЛДЭЛ / ГҮЙЛГЭЭГ СМА-НД МЭДЭЭЛЭХ НЬ

СМА, бусад хууль сахиулах байгууллагад мэдээлэл дамжуулах, солилцох, мэдээлэл гаргаж өгөх тогтолцоо

САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБА

# 01

# СМА-НЫ ТУХАЙ



# МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬ



Монгол Улсын Их Хурлаас 2006 оны 7 сарын 8-ны өдөр Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг баталсан.

# МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ТОГТОЛЦОО



# САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБАНЫ ТУХАЙ




**МУТСТ тухай хууль 16.1 зүйл:**

**СМА нь** мөнгө угаах гэмт хэрэг, түүнд холбогдох гэмт хэрэг, зөрчил болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой мэдээлэл, энэ хуулийн 4.1-д заасан этгээдээс энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан **мэдээллийг хүлээн авах, мэдээлэлд дүн шинжилгээ хийх,** дүн шинжилгээний үр дүнд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэж сэжиглэсэн гүйлгээ, гүйлгээний оролдлогын талаарх **мэдээллийг** эрх бүхий хууль сахиулах байгууллагад **шилжүүлэх** чиг үүрэг бүхий **хараат бус, бие даасан байгууллага** байна.



# МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГТЭЙ ЭТГЭЭД

CMA

- Банк
- ҮМ, ҮЧ, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч
- Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага
- Хуульч, нотариатч, нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч
- ХО-ын сан, ХО-ын менежментийн компани
- Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч
- Банк бус санхүүгийн байгууллага
- Хадгаламж зээлийн хоршоо
- Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага
- Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогч



...нь өөрийн харилцагчтай холбоотой дараах ажиллагааг бэлтгэсэн, хийсэн, эсхүл оролцсон бол:

а. үл хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авах;
б. харилцагчийн хөрөнгийг удирдах;
в. банкны, хадгаламжийн, үнэт цаасны дансыг удирдах;
г. компанийг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааг явуулах, удирдахад зориулан хөрөнгө татах, бүрдүүлэхийг зохион байгуулах;
д. хуулийн этгээдийг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааг явуулах, удирдах, эсхүл хэлцлийн үндсэн дээр аливаа тодорхой үйл ажиллагаа явуулах, удирдах, эсхүл аж ахуйн нэгжийг худалдах, худалдан авах.

# ГҮЙЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ

01 — Бэлэн мөнгөний гүйлгээ

02 — Гадаад төлбөр тооцооны гүйлгээ

03 — Виртуал хөрөнгийн гүйлгээ

04 — Сэжигтэй гүйлгээ

20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй

- ✓ бэлэн мөнгөний
- ✓ гадаад төлбөр тооцооны
- ✓ виртуал хөрөнгийн гүйлгээний тухай мэдээллийг

МҮЭ гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын 5 өдрийн дотор батлагдсан маягт журмын дагуу СМА-нд мэдээлнэ.

**Нотариатч, хуульч,** эсхүл нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нь **өөрийн харилцагчтай холбоотой дараах ажиллагааг бэлтгэсэн, хийсэн, эсхүл оролцсон бол:**

а. Үл хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авах;

б. Харилцагчийн хөрөнгийг удирдах;

в. Банкны, хадгаламжийн, үнэт цаасны дансыг удирдах;

г. Компанийг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааг явуулах, удирдахад зориулан хөрөнгө татах, бүрдүүлэхийг зохион байгуулах;

д. Хуулийн этгээдийг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааг явуулах, удирдах, эсхүл хэлцлийн үндсэн дээр аливаа тодорхой үйл ажиллагаа явуулах, удирдах, эсхүл аж ахуйн нэгжийг худалдах, худалдан авах.

# ДҮН ШИНЖИЛГЭЭ

1. СЭЖИГТЭЙ ГҮЙЛГЭЭНД ХИЙХ ДҮН ШИНЖИЛГЭЭ:

   Өөрт байгаа болон эрх бүхий бусад байгууллагаас авч болох мэдээллийг ашиглан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой байж болзошгүй этгээдүүдийг тодорхойлох, тэдгээрийн явуулж буй үйл ажиллагаа, хийж буй гүйлгээг судлах, тухайн этгээдүүдийн хоорондын холбоо, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, түүнтэй холбоотой суурь гэмт хэргүүд болон хууль бус үйл ажиллагаанаас олсон байж болзошгүй орлого зэргийг тодорхойлох зорилгоор хийх дүн шинжилгээ

2. СТРАТЕГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ:

   Өөрт байгаа болон эрх бүхий бусад байгууллагаас авч болох мэдээ, мэдээллийг ашиглан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх арга хэлбэр, чиг хандлага, хэв шинж болон төлөв байдлыг тодорхойлох зорилгоор хийх дүн шинжилгээ

Мэдээлэл хүлээн авах → Дүн шинжилгээ хийх → Шилжүүлэх



# МЭДЭЭЛЭЛ ШИЛЖҮҮЛЭХ

## Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үндэслэлтэй гүйлгээ байна гэж үзсэн тохиолдолд

- АТГ
- ЦЕГ
- ТЕГ

**Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль**

# САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБА

**Мэдээлэх үүрэгтэй этгээд**



**Хууль сахиулах байгууллага**

- Мэдээллийн нууцлалыг хамгаалах
- Сэжигтэй байж болзошгүй гэж үзэн ирүүлсэн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үндэслэл бүхий мэдээллийг шүүж шилжүүлснээр хууль сахиулах байгууллагын ажлыг хөнгөвчлөх
- Нууцлал бүхий мэдээллийн хэрэгцээгүй урсгалыг хязгаарлах



02

# СЭЖИГТЭЙ ГҮЙЛГЭЭГ МЭДЭЭЛЭХ НЬ



# СЭЖИГТЭЙ ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН МЭДЭЭЛЭХ

МҮЭ нь “Хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол” Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т заасны дагуу сэжигтэй гүйлгээг СМА-нд мэдээлэх үүрэгтэй.

- ✓ Сэжигтэй гүйлгээг таних, илрүүлэх;
- ✓ Хэвийн бус, эргэлзээтэй санагдсан гүйлгээ, харилцагчийг нэмж судлах;
- ✓ Сэжигтэй гүйлгээний тайлангаар мэдээлэх шаардлагатай эсэх шийдвэр гаргах;
- ✓ Сэжигтэй гүйлгээний тайлангийн маягт бөглөх;
- ✓ Сэжиглэх үндэслэлийг тодорхой, тайлбарыг дэлгэрэнгүй бичих;
- ✓ Бөглөсөн СГТ-нг нууц үгээр хамгаалан СМА-нд илгээх.



# ГҮЙЛГЭЭНИЙ ХЯНАЛТ

**ХТМ**

- Эрсдэлийн үнэлгээ хийх
- Харилцагчийг таньж мэдэх арга хэмжээг хэрэгжүүлэх

**Эрсдэлд суурилсан аргачлал**

- Эрсдэлийн үзүүлэлт /параметр/, хяналт тавих гүйлгээний дүн, эрсдэлтэй гүйлгээний тохиолдлыг тодорхойлох
- Турших
- Мэдээллийн чанарыг үнэлэх

**Хяналт тавих**

- Гүйлгээ хийх эсхүл үйлчилгээ үзүүлэхээс өмнө шалгах
- Сэжигтэй тохиолдол үүсвэл журам, зааврын дагуу арга хэмжээ авах
- Баримтжуулах

**Шийдвэрлэх, сайжруулах**

- СГТ бөглөх
- СГТ-нг СМА-нд мэдээлэх
- Систем үр дүнтэй ажиллаж байгаа эсэхийг үнэлэх, засаж сайжруулах шаардлагатай зүйлсийг сайжруулах

Хяналт тавих үе шатууд

# СЭЖИГТЭЙ ГҮЙЛГЭЭ ИЛРҮҮЛЭХ

**СГ-ний шинж тэмдгийг тодорхойлох /Red Flags/**

Сэжигтэй гүйлгээ байж болзошгүйг илэрхийлэх шинж тэмдгүүд байгаа эсэх шалгах

**Гүйлгээг шалгах**

- Харилцагчийн гүйлгээний түүх, ХТМ хүрээнд авсан мэдээллийг шалгах, мэдээлэл цуглуулах
- Асуулт асуух

**Цуглуулсан мэдээллийг харьцуулах**

Цуглуулсан мэдээллийг тулгаж харьцуулах, эдгээр нь харилцагчийн ажил, бизнес, профайлтай нийцэж байгаа эсэхийг үнэлэх

**Үнэлэх**

Сэжигтэй гүйлгээ мөн эсэхийг үнэлэх



# СЭЖИГТЭЙ ГҮЙЛГЭЭНИЙ ТҮГЭЭМЭЛ ШИНЖ ТЭМДГҮҮДИЙГ МЭДЭХ НЬ ЮУНД ХЭРЭГТЭЙ ВЭ?

СГТ-ИЙН ШИНЖ ТЭМДЭГ






Эх үүсвэр: AML Singapore

# СЭЖИГТЭЙ ГҮЙЛГЭЭНИЙ ШИНЖ ТЭМДГҮҮД

- ✓ ХАРИЛЦАГЧИЙГ ТАНЬЖ МЭДЭХТЭЙ ХОЛБООТОЙ ШИНЖ ТЭМДГҮҮД
- ✓ ХАРИЛЦАГЧИЙН ЗАН ТӨЛӨВТЭЙ ХОЛБООТОЙ ШИНЖ ТЭМДГҮҮД
- ✓ САНХҮҮГИЙН ГҮЙЛГЭЭТЭЙ ХОЛБООТОЙ ШИНЖ ТЭМДГҮҮД
- ✓ ДАНСНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ӨӨРЧЛӨЛТТЭЙ ХОЛБООТОЙ ШИНЖ ТЭМДГҮҮД
- ✓ ГҮЙЛГЭЭГ МЭДЭЭЛЭХ ЭСВЭЛ ТАНИХ ШААРДЛАГААС ЗАЙЛСХИЙХТЭЙ ХОЛБООТОЙ ШИНЖ ТЭМДГҮҮД
- ✓ БУСАД ТАЛУУДЫГ АШИГЛАХТАЙ ХОЛБООТОЙ ШИНЖ ТЭМДГҮҮД
- ✓ ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ШИНЖ ТЭМДГҮҮД
- ✓ НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОЛОН САНХҮҮГИЙН МЕНЕЖМЕНТИЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА САЛБАРТАЙ ХОЛБООТОЙ ШИНЖ ТЭМДГҮҮД



# ХУУЛЬЧ, ӨМГӨӨЛӨГЧИДТЭЙ ХОЛБООТОЙ СЭЖИГТЭЙ ГҮЙЛГЭЭНИЙ ТҮГЭЭМЭЛ ШИНЖ ТЭМДГҮҮД

- ✓ ӨӨРӨӨ БОЛОН ХАМААРАЛ БҮХИЙ ХҮМҮҮСИЙН ТАЛААР ГЭМТ ХЭРЭГТЭЙ ХОЛБООТОЙ БОЛОН ОЛОН НИЙТЭД СӨРӨГ МЭДЭЭЛЭЛ ТАРХСАН УТНБЭ,
- ✓ ГАДААД УЛСАД ХАЛХАВЧ КОМПАНИ ЭСВЭЛ НЭРЛЭСЭН БОЛОН ЭЗЭМШИГЧИЙН ХУВЬЦАА (BEARER SHARE)-ТАЙ КОМПАНИТАЙ ХАМААРАЛТАЙ ХАРИЛЦАГЧ,
- ✓ ӨӨРӨӨ БОЛОН ХОЛБООТОЙ ЭТГЭЭД НЬ ХОРИГ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТАД ОРСОН,
- ✓ МУТСТ ШААРДЛАГА БОЛОН ТУХАЙН ГЭРЭЭ/ГҮЙЛГЭЭГ ХУРДАН ХИЙХ ТАЛААР ШААРДЛАГАГҮЙ ХҮСЭЛТ ГАРГАХ,
- ✓ ЖИРИЙН ХУУЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ШАЛТГААНГҮЙ ӨНДӨР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР ТӨЛӨХ,
- ✓ ХАРИЛЦАГЧ НЬ ЯМАР НЭГЭН ШАЛТГААНГҮЙГЭЭР БЭЛЭН МӨНГӨ АШИГЛАХЫГ ХИЧЭЭХ, ШААРДАХ,
- ✓ ТАЛУУДЫН ХООРОНД ҮХХ-ТЭЙ ХОЛБООТОЙ ШИЛЖҮҮЛГИЙГ ОНЦГОЙ БОГИНО ХУГАЦААНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭХ,
- ✓ ТУХАЙН ХУУЛИЙН ЭТГЭЭД ҮҮСГЭН БАЙГУУЛАГДСНЫХАА ДАРАА ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧИЙГ НЬ ТОДОРХОЙЛОХОД ХҮНДРЭЛТЭЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДТЭЙ ХОЛБООТОЙ ГҮЙЛГЭЭ ХИЙХ,



# СГТ БӨГЛӨХӨД АНХААРАХ ЗҮЙЛ

- ✓ СГТ-ийн маягтын “В Хэсэг. Сэжиглэх үндэслэл”-ийн 25 дахь баганад “Сэжиглэх үндэслэл”, 26 дахь баганад “Тайлбар” хэсэг байгаа.

- ✓ СГТ-ийн **СЭЖИГЛЭХ ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР**-ыг тодорхой, бүрэн, дэлгэрэнгүй бичих шаардлагатай. Дараах мэдээллийг агуулсан байвал зохино. Үүнд:
  - хийгдсэн гүйлгээ, болсон үйл явдал,
  - үүсээд буй нөхцөл байдал,
  - харилцагч, гүйлгээг таньж мэдэх арга хэмжээ авах үед авсан, мэдсэн мэдээлэл,
  - зөрүүтэй, үл нийцсэн шинж байдал,
  - яагаад тухайн гүйлгээ, мэдээллийг сэжигтэй байна гэж үзсэн,
  - боломжтой бол ямар гэмт хэрэг, хууль бус үйл ажиллагаатай холбоотой байж болзошгүй байгаа талаарх мэдээлэл.

ХЭН?
ЮУ?
ХЭЗЭЭ?
ХААНА?
ЯАЖ?
ЯАГААД?



# 03

# СГТ
# НЭМЭЛТ
# МЭДЭЭЛЭЛ



# СЭЖИГТЭЙ ГҮЙЛГЭЭНИЙ НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ

## 9 дүгээр зүйл.Сэжигтэй гүйлгээний тухай мэдээлэл

9.1.СМА-нд хүргүүлэх сэжигтэй гүйлгээний тухай мэдээлэл дараах агуулгатай байна:

9.1.1.энэ хуулийн 4.1-д заасан этгээдийн нэр, оршин байгаа газрын хаяг болон мэдээлэл хүргүүлсэн албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;

9.1.2.харилцагч, хүлээн авагчийн талаарх мэдээлэл;

9.1.3.тухайн гүйлгээний утга, үнийн дүн, гүйцэтгэсэн хэлбэр, он, сар, өдөр, дансны дугаар, гүйлгээний бусад оролцогч болон данс эзэмшигчийн талаарх мэдээлэл;

9.1.4.тухайн гүйлгээг сэжиглэх болсон үндэслэл, нөхцөл байдлын тухай товч тайлбар;

9.1.5.холбогдох бусад баримт бичиг.

- СМА нь сэжигтэй гүйлгээтэй холбогдсон этгээдийн нэмэлт мэдээллийг энэ хуулийн 4.1-д заасан этгээдээс гаргуулан авах эрхтэй.





# 04

# СГТ МЭДЭЭЛЭХЭД АНХААРАХ ЗҮЙЛ

# МЭДЭЭЛЛИЙН НУУЦЛАЛЫГ ХАДГАЛАХ



**Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль:**

**13 дугаар зүйл.Мэдээллийн нууцлалыг хадгалах**

13.1.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд, түүний удирдлага, ажилтан нь Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлсэн гүйлгээтэй холбоотой аливаа мэдээллийг энэ хуулийн 7.4-т заасанаас бусад этгээдэд дамжуулах, задруулахыг хориглоно.

**TIPPING OFF**

# ХАРИУЦЛАГААС ЧӨЛӨӨЛӨХ

**Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль:**



12.1.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд Санхүүгийн мэдээллийн алба болон эрх бүхий байгууллагад энэ хуульд заасан журмын дагуу мэдээлэл өгснийг банкны, мэргэжлийн, мэргэжлийн үйл ажиллагааны, үйлчлүүлэгчийн, аж ахуйн нэгж, байгууллагын, бизнесийн болон бусад нууц задруулсан гэж үзэхгүй.

12.2.Энэ хуулийн 4.1-д заасан этгээдийн өгсөн мэдээлэл мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх зорилгогүй байсныг тогтоосон нь тухайн мэдээлэл өгсөн иргэн, хуулийн этгээдийг мэдээлэл өгсөнтэй нь холбогдуулан Эрүүгийн хууль, Иргэний хууль болон бусад хуульд заасан аливаа хариуцлагад татах үндэслэл болохгүй.

goaml.mongolbank.mn/Home

Gmail | Санхүүгийн мэдээл... | google translate -... | ICA | МОНГОЛБАНКНЫ... | PDF Merge - Combi... | Drawing.vsdx | Homepage - ECOFE... | Basel Institute on G... | Federal courses | usa co haih | USA-hailt | Toastmasters Intern...

EN | MN

САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБА

# МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГТЭЙ ЭТГЭЭДЭЭС

## ТАЙЛАН ХҮЛЭЭН АВАХ ПОРТАЛ

НЭВТРЭХ>>

### Бүртгүүлэх

Системд нэвтрэхийн тулд та эхлээд мэдээлэх үүрэгтэй этгээдээр "Байгууллага бүртгүүлэх" цэсийг ашиглан бүртгүүлэх шаардлагатай. Бүртгүүлсний дараа хэрэглэгчийн нэр болон нууц үгээ ашиглан системд нэвтэрнэ үү.

Бүртгүүлэх

### Гарын авлага

Системд нэвтрэхээс өмнө goAML WEB гарын авлагатай танилцана уу

Гарын авлага

### Холбоо барих

Бага тойруу-3, 15160
Улаанбаатар-46, Монгол Улс
Утас: 976-11-326161, 976-11-321919
Факс: 976-11-311471
E-mail: fiu@mongolbank.mn
Веб: https://fiu.mongolbank.mn/

И-мэйл

© 2023 UNODC, All rights reserved. Version 4.9.2.0

# 05

# ГАРЫН АВЛАГА, ЗААВАР ЗӨВЛӨМЖ



# ГАРЫН АВЛАГА, ЗААВАР ЗӨВЛӨМЖ


Монголбанк
Санхүүгийн мэдээллийн алба

САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБАНД МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГТЭЙ ЭТГЭЭДЭЭС ЦАХИМААР МЭДЭЭЛЭЛ ИРҮҮЛЭХ ЖУРМЫН ДАГУУ ТАЙЛАН БӨГЛӨХ ЗААВАР, ЗӨВЛӨМЖ

МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГТЭЙ ЭТГЭЭД | НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОЛОН САНХҮҮГИЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ

2020 он


Монголбанк
Санхүүгийн мэдээллийн алба

СЭЖИГТЭЙ ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН МЭДЭЭЛЭХ ГАРЫН АВЛАГА

МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГТЭЙ ЭТГЭЭД

2020 оны 5 дугаар сар


Монголбанк
Санхүүгийн мэдээллийн алба

СЭЖИГТЭЙ ГҮЙЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР БИЧИХ ЗӨВЛӨМЖ

Мэдээлэх үүрэгтэй этгээд: Банк

2020 он


Монголбанк
Санхүүгийн мэдээллийн алба

МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ БАЙЖ БОЛЗОШГҮЙ СЭЖИГТЭЙ ГҮЙЛГЭЭНИЙ ШИНЖ ТЭМДГҮҮД

МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГТЭЙ ЭТГЭЭД | ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГА

2021 он
3 сар

# СМА-ны цахим хуудас www.fiu.mongolbank.mn









# МУТСТ мэдээллийн нэгдсэн систем www.amlcft.mn

# АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА.




САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБА

Цахим хуудас: fiu.mongolbank.mn
И-мэйл: fiu@mongolbank.mn
Утас: 326161, 321919, 321199